БАТЛАВ.
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН
ДАРГА Н.УУГАНБАЯР

24... оны 1... сарын 4...

# БҮС, ОРОН НУТАГ ДАХЬ ГАЗРУУДЫН 2024 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 01 дүгээр сарын 03 Улаанбаатар хот

Нэг. Төлөвлөгөөний зорилт

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн $5_1$ дүгээр зүйлд зааснаар бүс, орон нутаг дахь газруудын хэмжээнд 2024 онд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж буй хувь хүн, хуулийн этгээдүүд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавихад оршино.

Бүс орон нутаг дахь газрууд хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд Зөрчил шалган шийдвэрлэх газарт урьдчилан мэдэгдэж, батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг зохион байгуулж, үр дүнг тухайн бүр танилцуулна.

Хоёр. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх хугацаа

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хавсралтаар батлагдсан төлөвлөгөөний дагуу хийнэ.

Гурав. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх, бүрэлдэхүүн.

Орон нутаг дахь газрын гадаадын иргэний хяналтын улсын (ахлах) байцаагч, мэргэжилтнүүд төлөвлөгөөт хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн хүрээнд тодорхой чиглэлээр, заасан хугацаанд зохион байгуулна.

Дөрөв. Төлөвлөгөөт хяналт шалгалтын чиглэл, хугацаа.

Орон нутаг дахь газар тус бүрийн хяналт шалгалтын төлөвлөгөөг хавсралтаар батлуулж, хяналт шалгалт хийгдэх хугацаа, хамрах хүрээг төлөвлөгөөнд нарийвчлан тусгана.

Тав. Төлөвлөгөөний биелэлт, үр дүнг тайлагнах.

Орон нутаг дахь газрууд төлөвлөгөөт хяналт шалгалтын удирдамжийг тухай бүр Зөрчил шалган шийдвэрлэх газарт хүргүүлнэ.

Зөрчил шалган шийдвэрлэх газар нь орон нутаг дахь газруудыг төрийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд нь мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг хэрхэн зохион байгуулсан, шалгалтын үр дүнг байгууллагын удирдлагад илтгэх хуудсаар ажлын 5 өдрийн дотор танилцуулахаар Зөрчил шалган шийдвэрлэх газарт ирүүлнэ.

Зургаа. Төлөвлөгөөт хяналт шалгалтын зардал

Тухайн санхүүгийн жилд батлагдсан улсын төсвийн хөрөнгөнөөс холбогдох хяналт шалгалтын зардлыг гаргана.

--- оОо ---

Бүс орон нутаг дахь газруудын
2024 оны хяналт шалгалтын
төлөвлөгөөний нэгдүгээр хавсралт

# АГААРЫН ЗАМЫН БООМТ ХАРИУЦСАН ГАЗРЫН 2024 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хяналт шалгалтын чиглэл | Хяналт шалгалт явуулах хугацаа |
|---|---|---|
| 1 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл гомдол мэдээллээр тухай бүр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 2 | Хариуцсан нутаг дэвсгэрт оршин сууж буй гадаадын иргэдэд бүртгэлээр хяналт тавих, илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэж үр дүнгийн талаар удирдлагад танилцуулах | Тухай бүр |
| 3 | Хариуцсан нутаг дэвсгэрт махны үйлдвэр, малын гаралтай түүхий эд худалдан авах, борлуулах, боловсруулах үйлдвэрт хөдөлмөр эрхэлж байгаа болон хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэдийн паспорт, баримт бичигт хяналт шалгалт хийх | 2, 3 дугаар улирал |
| 4 | Хариуцсан нутаг дэвсгэрт барилга, зам гүүр, үйлдвэрлэлийн барилга байгууламж, уул уурхай болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхэлж байгаа болон хөрөнгө оруулагч гадаадын иргэдийн паспорт, баримт бичигт хяналт шалгалт хийх | 2, 3 дугаар улирал |
| 5 | Боловсрол, шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй сургууль, сургалтын төв, сүм хийдийн үйл ажиллагаанд оролцож буй гадаадын иргэдийн паспорт, баримт бичигт хяналт шалгалт хийх | 3, 4 дүгээр улирал |
| 6 | Хариуцсан нутаг дэвсгэрт газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын иргэдийн паспорт, баримт бичигт хяналт шалгалт хийх | 2, 3 дугаар улирал |
| 7 | Чингисхаан, Буянт-Ухаа ОУНБ-ын хамгаалагдсан бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагад ажиллаж буй гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх | 3, 4 дүгээр улирал |
| 8 | Хууль хяналтын байгууллагатай хамтарсан шалгалт зохион байгуулах | Тухай бүр |
| 9 | Орон нутгийн нислэгээр зорчигч гадаадын иргэний паспорт, баримт бичигт хяналт шалгалт хийх | Тухай бүр |

Бүс орон нутаг дахь газруудын
2024 оны хяналт шалгалтын
төлөвлөгөөний хоёрдугаар хавсралт

# ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН 2024 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хяналт шалгалтын чиглэл | Хяналт шалгалт явуулах хугацаа |
|---|---|---|
| 1 | Бүсийн хэмжээнд оршин сууж буй гадаадын иргэний виз, оршин суух зөвшөөрөлд бүртгэлээр (ISM) хяналт тавьж, илэрсэн зөрчлийг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх | Сар бүр |
| 2 | Уул уурхай, газрын тос, ашигт малтмал, хайгуулийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж, ахуй нэгжид ажиллаж буй гадаадын иргэдийн виз, оршин суух зөвшөөрөл нь холбогдох хууль, журамд нийцэж буй эсэхэд хяналт шалгалт хийх | 3,4 дугаар улирал |
| 3 | Барилга угсралт, зам гүүр, бүтээн байгуулалт, тээвэр, үйлдвэрлэл үйлчилгээ, хадлан тэжээл, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагад хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх | 2,4 дүгээр улирал |
| 4 | Мал, малын гаралтай түүхий эд боловсруулах, үйлдвэр аж ахуйн нэгж, худалдах авах, борлуулах үйл ажиллагаа явуулж буй цэгт хяналт шалгалт хийх | 1,4 дүгээр улирал |
| 5 | Шашны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй газрууд, тэдгээрт оролцож байгаа гадаадын иргэдийн бичиг баримт, эрх бүхий байгууллагаас олгодог тусгай зөвшөөрөл нь хүчинтэй эсэх зэрэгт хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэж ажиллах | 2 дугаар улирал |
| 6 | Эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж буй гадаадын иргэдийн паспорт, баримт бичигт хяналт шалгалт хийх | 1, 3 дугаар улирал |
| 7 | Монгол Улсын иргэнтэй гэр бүл болсон, цагаач, харьяалалгүй иргэдийн паспорт болон түүнийг орлох баримт бичиг, оршин суух зөвшөөрөл нь зөрчилтэй эсэхэд хяналт шалгалт хийх | 1 дүгээр улирал |
| 8 | Монгол Улсад цагаачлан болон гэр бүлийн шалтгаанаар оршин суух, оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан гадаадын иргэний ахуй амьдрал, ажлын байранд төвөөс өгсөн үүрэг, чиглэлийн дагуу хяналт шалгалт хийж, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргах | Тухай бүр |
| 9 | Хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр гадаадын иргэд, аж ахуй нэгж байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар тавигдсан мэдээлэлд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд хяналт шалгалт хийж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах | Тухай бүр |

Бүс орон нутаг дахь газруудын
2024 оны хяналт шалгалтын
төлөвлөгөөний гуравдугаар хавсралт

# ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН 2024 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хяналт шалгалтын чиглэл | Хяналт шалгалт явуулах хугацаа |
|---|---|---|
| 1 | Дорноговь, Говьсүмбэр аймгийн хэмжээнд оршин сууж буй гадаадын иргэдийн виз, оршин суух зөвшөөрлийн талаарх судалгаа ISM сүлжээнээс гаргаж, үр дүнг тооцон илэрсэн зөрчлийг хууль журмын дагуу шийдвэрлэх | Тухай бүр |
| 2 | Дорноговь, Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт уул уурхай, нүүрс, хүдэр, жонш угаах үйлдвэрт ажиллаж буй хөрөнгө оруулагч, хөдөлмөр эрхлэгч гадаадын иргэдийн бичиг баримтад шалгалт хийх, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх | Тухай бүр |
| 3 | Дорноговь, Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрт барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэх | Тухай бүр |
| 4 | Мал, малын гаралтай түүхий эд боловсруулах, худалдан авах, борлуулах үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид ажиллаж буй гадаадын иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 5 | Эрүүл мэнд, боловсрол, шашин, гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа, гадаадын иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 6 | Нийтийн хоол, зочид буудал, автозасвар, худалдаа үйлчилгээний салбарт хөрөнгө оруулагч, хөдөлмөр эрхлэгч гадаадын иргэний паспорт, бичиг баримтад хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 7 | Хариуцсан нутаг дэвсгэрт төмөр зам, авто замын тээврийн хэрэгслээр зорчих гадаадын иргэдийн шилжил хөдөлгөөн болон хил орчмын нутагт зорчин үнэмлэхтэй гадаадын иргэний хөдөлгөөнд хяналт тавих, баримт бичигт үзлэг шалгалт хийх | Тухай бүр |
| 8 | Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд цагаачлан болон гэр бүлийн шалтгаанаар оршин суух, түүнийг сунгуулах хүсэлт гаргасан гадаадын иргэнд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хяналт шалгалт хийж, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гаргах | Тухай бүр |
| 9 | Хууль, хяналтын бусад байгууллагын хүсэлтийг үндэслэн Байгууллагын дарга нарын хамтран баталсан удирдамжийн дагуу гадаадын иргэний бичиг баримтад хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 10 | Гомдол мэдээллийн дагуу хяналт шалгалт хийх | Тухай бүр |

Бүс орон нутаг дахь газруудын
2024 оны хяналт шалгалтын
төлөвлөгөөний дөрөвдүгээр хавсралт

# ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН 2024 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хяналт шалгалтын чиглэл | Хяналт шалгалт явуулах хугацаа |
|---|---|---|
| 1 | Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд, Манлай сумын нутаг дэвсгэрт барилга угсралт, зам гүүр, уул уурхайн олборлолт, хайгуул болон нүүрсний тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийх | 1, 2, 3, 4 дүгээр улирал |
| 2 | Баяндалай, Ноён, Гурвантэс, Сэврэй сумдын нутаг дэвсгэрт барилга, зам, уул уурхайн олборлолт, хайгуул болон нүүрс тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийх | 1, 3, 4 дүгээр улирал |
| 3 | Номгон, Хүрмэн сумдын нутаг дэвсгэрт уул уурхайн олборлолт, хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийх | 2 дугаар улирал |
| | Дундговь аймагт хийх хяналт шалгалт | |
| 4 | Адаацаг, Сайнцагаан, Баянжаргалан, Гурвансайхан, Говь-Угтаал сумдад уул уурхайн олборлолт, хайгуул болон нүүрс тээврийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| | Өвөрхангай аймагт хийх хяналт шалгалт | |
| 5 | Аймгийн нутаг дэвсгэрт Олон Улсын байгууллага, сүм хийд, шашны байгууллагууд, авто зам засвар, зочид буудал, мах, түүхий эд, боловсруулах үйлдвэр тэдгээрт ажиллаж байгаа гадаадын иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| | Баянхонгор аймагт хийх хяналт шалгалт | |
| 6 | Баянхонгор, Бөмбөгөр, Бууцагаан, Галуут, Баян-Овоо, Баянцагаан, Баацагаан сумдад уул уурхайн олборлолт, хайгуул болон авто зам барилгын бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| | Орон нутгийн төвд хийх хяналт шалгалт | |
| 7 | Өмнөговь аймгийн Даланзадгад, Дундговь аймгийн Сайнцагаан, Өвөрхангай аймгийн Арвайхээр, Баянхонгор аймгийн Баянхонгор сумын нутагт Олон Улсын байгууллага, сүм хийд, шашны байгууллагууд, авто зам засвар, зочид буудал, мах, түүхий эд боловсруулах үйлдвэр тэдгээрт ажиллаж байгаа гадаадын иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх | Тухай бүр |

Бүс орон нутаг дахь газруудын
2024 оны хяналт шалгалтын
төлөвлөгөөний тавдугаар хавсралт

# БАРУУН БҮС ДЭХ ГАЗРЫН 2024 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хяналт шалгалтын чиглэл | Хяналт шалгалт явуулах хугацаа |
|---|---|---|
| 1 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийх, үр дүнгийн талаар хариу мэдэгдэх | Тухай бүр |
| 2 | Бүсийн хэмжээнд оршин сууж буй гадаадын иргэдэд бүртгэлээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэх, үр дүнгийн талаар удирдлагад танилцуулах | Тухай бүр |
| 3 | Орон нутгийн нислэг, хот хоорондын нийтийн тээврээр зорчиж байгаа гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 4 | Мал, малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр аж ахуйн нэгж, худалдан авах, борлуулах үйл ажиллагаа явуулж буй цэгт хяналт шалгалт хийх | 4 дүгээр улиралд |
| 5 | Уул уурхай, ашигт малтмал хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллаж буй гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх | 2, 3 дугаар улиралд |
| 6 | Шашин, төрийн болон төрийн бус Олон улсын байгууллагын үйл ажиллагаа, тус шугамаар Монгол Улсад оршин сууж буй гадаадын иргэдийн паспорт, баримт бичигт хяналт шалгалт хийх | 1, 3 дугаар улиралд |
| 7 | Эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж буй гадаадын иргэдийн паспорт, баримт бичигт хяналт шалгалт хийх | 1, 4 дүгээр улиралд |
| 8 | Барилга, байгууламж, дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид ажиллаж буй гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх | 2, 3 дугаар улиралд |
| 9 | Монгол Улсад байнга оршин суух хүсэлт гаргасан болон оршин суух зөвшөөрлөө сунгуулах хүсэлт гаргасан гадаадын иргэний нөхцөл байдлыг тогтоох зорилгоор хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 10 | Түр ирэгчээр бүртгүүлсэн гадаадын иргэнийг хугацаандаа Монгол Улсаас гарч байгаа эсэхэд бүртгэлээр хяналт тавих | Тухай бүр |
| 11 | Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т заасан гадаадын иргэнийг орон байраар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын цахим бүртгэлд хяналт тавих | Тухай бүр |
| 12 | Хилээр нэвтэрч байгаа гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт тавих, тэдэнтэй ярилцлага хийх, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн Тавдугаар бүлэгт заасан Монгол Улсад орох, дамжин өнгөрч байгаа эсэхэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд мөн хуулийн 22 дугаар зүйлд заасан арга хэмжээг авах | Тухай бүр |
| 13 | Хууль хяналтын бусад байгууллагатай хамтарсан шалгалт зохион байгуулах | Тухай бүр |
| 14 | Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, байгууллагын обьектын судалгаа хийх, орон нутгийн санд баяжилт хийх | Тухай бүр |

Бүс орон нутаг дахь газруудын
2024 оны хяналт шалгалтын
төлөвлөгөөний зургаадугаар хавсралт

# ХОЙД БҮС ДЭХ ГАЗРЫН 2024 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хяналт шалгалтын чиглэл | Хяналт шалгалт явуулах хугацаа |
|---|---|---|
| 1 | Соёл урлаг, спорт, боловсрол, эрүүл мэнд, шашин, хүмүүнлэгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагад бүртгэлтэй гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх | 2, 4 дүгээр улирал |
| 2 | Геологи, уул уурхай, эрчим хүч, газар тариалан, ойн дагалдах нөөц ашиглах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэд, хамаарал бүхий этгээд, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцож буй гадаадын иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх | 2, 3, 4 дүгээр улирал |
| 3 | Барилга угсралт, зам, гүүр, бүтээн байгуулалт, тээвэр, үйлдвэрлэл, үйлчилгээний болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж, байгууллагад хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэд, хамаарал бүхий этгээд, тэдгээрийн үйл ажиллагаанд оролцож буй гадаадын иргэдийн бичиг баримтад хяналт шалгалт хийх | 2, 3, 4 дүгээр улирал |
| 4 | Цагаач, гэр бүлийн шалтгаанаар болон хувийн бусад хэлбэрээр оршин сууж буй гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх | 1, 2 дугаар улирал |
| 5 | Иргэн, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч, байгууллагын удирдлагад танилцуулан төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 6 | Хууль хяналтын байгууллагатай хамтарсан шалгалт зохион байгуулах | Тухай бүр |

Бүс орон нутаг дахь газруудын
2024 оны хяналт шалгалтын
төлөвлөгөөний долоодугаар хавсралт

## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хяналт шалгалтын чиглэл | Хяналт шалгалт явуулах хугацаа |
|---|---|---|
| 1 | Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг байгууллагад танилцуулан үүрэг чиглэл авч тухай бүр нь төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 2 | Аймгийн хэмжээнд оршин суугаа буй гадаадын иргэдэд бүртгэлээр хяналт тавьж, илэрсэн зөрчлийг хуулийн дагуу шийдвэрлэх, үр дүнгийн талаар удирдлагад танилцуулах | Тухай бүр |
| 3 | Орон нутгийн нислэг, хот хоорондын нийтийн тээврээр зорчиж байгаа гадаадын иргэдийн хөдөлгөөнд хяналт шалгалт хийх | Тухай бүр |
| 4 | Аймгийн хэмжээнд авто зам, гүүр, барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийх | 2, 4 дүгээр улирал |
| 5 | Мал, малын гаралтай түүхий эд боловсруулах, худалдан авах, борлуулах үйл ажиллагаа явуулж буй цэгт хяналт шалгалт хийх | 4 дүгээр улиралд |
| 6 | Уул уурхай, ашигт малтмал хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад ажиллаж буй гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх | 1, 3 дугаар улиралд |
| 7 | Шашин, төрийн болон төрийн бус Олон Улсын байгууллагын шугамаар эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллаж буй гадаадын иргэдийн паспорт, баримт бичигт хяналт шалгалт хийх | 1, 3 дугаар улиралд |
| 8 | Барилга, байгууламж, дэд бүтэц, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид ажиллаж буй гадаадын иргэдэд хяналт шалгалт хийх | 2, 3 дугаар улиралд |
| 9 | Хууль хяналтын бусад байгууллагатай хамтарсан шалгалт зохион байгуулах | Тухай бүр |
| 10 | Хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж, байгууллагын обьектын судалгаа хийх, хяналт шалгалтын мэдээллийн санд баяжилт хийх | Тухай бүр |